

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС
2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 11 дүгээр сарын 29

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 11 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 1359 ширхгийг шинээр хэвлэн, 684 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 91 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын хоёр иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 1669 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 3606 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1598, 7585-1882 дугаарын утсаар 74, биечлэн 578, автомат хариулагчаар 1356 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Тайваны төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Анкара, Станбул хот дахь консулын ажилтанд утсаар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хот дахь консулын газар томилогдсон ажилтнуудад байгууллагын төвд виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, таван улсын гадаадын зургаан иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээр “J” ангиллын 38, “S” ангиллын 101, “A” ангиллын 7, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох 45, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 110 визийн зөвшөөрөл олгож, нийт давхардсан тоогоор 264 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 150 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 301 иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын нэг мэргэжилтэн ажиллаж 85 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 54 иргэнд визийн зөвшөөрөл, 68 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 132 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 29 иргэний ангиллыг сольж, 4 иргэний хаягийн өөрчлөлт хийж, 9 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 201 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 11 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувийн урилга олголт хоёр дахин, оршин суух зөвшөөрлийн хасалт 21.0 хувиар, түр ирэгчийн бүртгэл 6.8 хувиар, түр ирэгчийн хасалт 1.1 хувиар өссөн, харин визийн зөвшөөрөл олголт 12.3 хувиар, виз олголт 8.2 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 22.0 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 33.2 хувиар, визийн сунгалт 69.5 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:


Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй нэг хүн Монгол Улсын харьяат болж, мөн нэг удаагийн зарлигаар 19 иргэн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын нэг улсын харьяат болсон байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй нэг хүний хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлээ.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 41 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын дөрвөн улсын харьяат болох хүсэлт гаргасан 40 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн. Мөн гадаадын нэг улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 36 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй гурван хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 69 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3553 иргэн бүртгэлтэй байна.



Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 11 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Байгууллагын дарга болон хүүхэд үрчлэлт хариуцсан мэргэжилтэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Итали Улсын иргэн, гэр бүлд 2003-2019 оны хооронд үрчлэгдсэн 25 хүүхдүүдийн нөхцөл байдалтай биечлэн танилцав.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүлийн хүсэлтийг хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүлсэн. Мөн гадаадын хоёр улсын гэр бүлд үрчлүүлсэн дөрвөн хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн зургаан улсын 917 иргэн, харьяалалгүй нэг хүнийг байгууллагын даргын 28 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар гадаадын нэг улсын хоёр иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, нэг удаагийн тушаалаар гадаадын нэг иргэнийг хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 226 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр зургаан улсын 13 иргэнд гарах сануулга өгсөн.

Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газартай хамтарсан хяналт шалгалтаар Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо “Амар” зочид буудал, мөн дүүргийн 13 дугаар хороо “Ориентал” зочид буудал, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо “Юнион бьюлдинг”, Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороо “Кентавр” зочид буудал, Баянгол дүүргийн 19 дүгээр хороо “Секрет гарден” зочид буудал гэсэн 5 байршилд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэдийн бичиг баримтыг шалгаж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7-д зааснаар ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан үндэслэлээр байгууллагын дэд даргын 6 удаагийн тушаалаар нийтдээ 784 иргэнийг

Монгол Улсаас албадан гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд 759 иргэнийг улсын хилээр гаргаж, Замын-Үүд төмөр замын боомтоор Улаанбаатараас Эрээн чиглэлийн 668 дугаар галт тэргээр албадан гаргаж, цагдаагийн байгууллагатай хамтран хуяглан хүргэсэн.

Тайлант хугацаанд гурван удаагийн төлөвлөгөөт, 17 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 138 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 1995 иргэнийг хамруулсан ба 190 гадаадын иргэн, 170 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 397 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 145,650,000 /нэг зуун дөчин таван сая зургаан зуун тавин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2019 оны 11 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 4.4 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 36.0 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 15.4 дахин тус тус өссөн, харин гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 50.0 хувиар буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалын дагуу байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний биелэлт, “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” Засгийн газрын 2018 оны 01 дүгээр албан даалгаврыг 2018-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2019 оны хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны тайланг

нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан тус байгууллагаас 2016-2018 онд хийж хэрэгжүүлсэн болон 2019 онд хийж байгаа ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу бэлтгэн шалгалтын комисст танилцууллаа. Мөн архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын 2015 оны улсын үзлэгийн мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн шалгалтын комисст хүргүүлсэн.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 42 өргөдөл, хоёр гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 35 өргөдөл, хоёр гомдол шийдвэрлэгдэж, 7 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу 278 албан хаагчийн хувийн хэргийг баяжуулж, Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд байгууллагын төвийн 114 албан хаагчийн сар бүрийн тогтмол нэмэгдэл болон албан тушаалын өөрчлөлтүүдийн мэдээллийг 2019 оны 10 дугаар сарын байдлаар шинэчлэн оруулсан.

Албан хаагчдын цалингийн шатлал, зэрэг дэвийн судалгааг гаргаж байгууллагын даргын 2019 оны Б/275 дугаар тушаалаар төрийн захиргааны 70 албан хаагчийн цалингийн шатлал, Б/276 дугаар тушаалаар төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг 30 албан хаагчид шинээр, 44 албан хаагчид ахиулан олголоо.

Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж буй албан хаагчдыг ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах зорилгоор Удирдлагын академиас зохион байгуулж буй “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Үндэсний тагнуулын академитай хамтран зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдал, түүний бүрэлдэхүүн хэсэг” сэдэвт сургалт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод зохион байгуулагдсан “2019 оны хил хамгаалах болон хилээр орох-гарах асуудал хариуцсан ажилчдын сургалт”-д тус тус холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

Мөн тус байгууллагын Виз, зөвшөөрөл, харьяатын газрын ахлах мэргэжилтэн, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн нар “Улсын онцгой обьектод нэвтрэх гадаадын иргэний хяналт, шалгалт” сэдвээр Дотоодын цэргийн 805 дугаар ангийн 200 албан хаагчид мэдээлэл бэлтгэн, сургалт зохион байгуулав.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд холбогдох есөн мэдээ, нэг ярилцлага бэлтгэн тухай бүр байгууллагын болон мэдээллийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. Дээрх мэдээллүүд нь давхардсан тоогоор 47 цахим хуудас, 11 сонинд тус тус нийтлэгдсэн байна. Тухайлбал: Байгууллагын дэд даргын “30 хоногийн визээр ирсэн жуулчид Гадаадын иргэн, харьяатын газарт ямар нэгэн бүртгэл хийлгэдэггүй” гарчигтай тодруулга, тайлбар ярилцлага бэлтгэж “ikon.mn”, “zindaa.mn”, “news.mn”, “gogo.mn”, “mnb.mn”,

“24tsag.mn”, “isee.mn”, “polit.mn” цахим хуудас, өдөр тутмын “Засгийн газрын мэдээ”, “Өнөөдөр”, “Өглөөний сонин”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Монголын Үнэн”, “Монголын мэдээ” сонинд тус тус нийтлэгдсэн.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх байгууллагын санал, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тушаалын төсөлд өгөх саналыг тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх нээлттэй хэлэлцүүлэг болон тус хуулийн ажлын хэсгийн хуралдаанд холбогдох албан хаагчид оролцсон.

Байгууллагын дарга Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлд үрчлэгдсэн Монгол хүүхдүүдийн амьдрал аж ахуйтай биечлэн танилцах, Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны газраас зохион байгуулагдсан “Зорчигчийн мэдээллийн солилцоо” сэдэвт семинарт оролцохтой холбоотой бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Лионинь мужийн Шэнь Ян хотноо зохион байгуулагдсан “2019 оны хөгжиж буй орнуудын хил нэвтрэх баримт бичгийг шалгах тухай сургалт”, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг Аюулаас Хамгаалах Тэнхимийн үйл ажиллагаатай танилцах айлчлалд холбогдох албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгууллаа.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

“E-Visa” системийн хөгжүүлэлтийн хүрээнд визийн хүсэлт тус бүрийг PDF өргөтгөлд шилжүүлэн архивлах программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж ажиллагаанд орууллаа. Мөн албан хаагчдын ирүүлсэн хүсэлтийн дагуу байгууллагын бичиг хэрэг, архив, өргөдөл, гомдлын программ хангамжууд дээр 12 удаагийн өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийсэн.

2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6,27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 11 дүгээр сард 5,78 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 5,17 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 10 дугаар сарын байдлаар 5 тэрбум 191 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 1 тэрбум 943 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан

бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны төлөвлөгөөт туслах үйл ажиллагааны орлогоос давж биелсэн орлогыг зарцуулах хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлсэн.

2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 10 дугаар сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.2.6-д заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд тус байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгад хяналт шинжилгээ хийлээ.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Дорнод аймаг дахь Зүүн бүс дэх газарт төлөвлөгөөт, Ховд аймаг дахь Баруун бүс дэх газарт төлөвлөгөөт бус дотоод аудитын хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан шалгалтын дүнг удирдлагад танилцуулж, холбогдох зөвлөмжийг хүргүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд орон нутаг дахь газруудын “shilendans.gov.mn” цахим хуудсанд байршуулсан 2019 оны 10 дугаар сар, 3 дугаар улирлын мэдээлэлд байгууллагын даргын баталсан удирдамжийг удирдлага болгон хяналт тавьж ажилласан. Шалгалтын дүнтэй холбогдуулан зөрчлийг засаж ажиллах тухай зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 224 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй гадаадын 7 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 17 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын үед боомтыг түр горимоор нээх асуудлаар Гаалийн ерөнхий газрын хурлын танхимд зохион байгуулсан уулзалтад холбогдох албан хаагч оролцож, шаардлагатай тоног төхөөрөмж, орон байрны талаарх саналыг цахим шуудангаар Хилийн боомтын үндэсний зөвлөлд хүргүүлсэн. Мөн “Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөл”-ийн дэргэдэх нарийн бичгийн даргын Ажлын албанаас зохион байгуулсан хуралд Улаанбаатар хотын олон улсын шинэ

нисэх буудалд Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэт систем /APP/-ийг нэвтрүүлэх талаарх хангагч байгууллагуудын харьцуулсан судалгааг танилцууллаа.

Үйл ажиллагаа явуулж буй хилийн 14 боомтод ажлын өдрийн 09:00, 16:00 цагуудад хил нэвтрэлт, онцлог нөхцөл, удирдлагын үүрэг, даалгаврыг нийт 63 удаа авч, бүртгэлийн дэвтэрт хөтлөн ажиллалаа. Түүнчлэн байгууллагын даргын 2019 оны 08 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан орон нутаг дахь газруудаас гадаад иргэдийн хил нэвтрэлт, хил дээрээс буцаасан тоон мэдээг өдөр бүр нэгтгэж удирдлагад танилцуулан ажиллаж байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР